

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2016 ОНЫ I УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Авлигатай тэмцэх газар нь хуулиар хүлээсэн чиг үүрэг, 2016 онд дэвшүүлсэн зорилт, жил, улирлын төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг хэрэгжүүлж ажилласан бөгөөд эхний улиралд хийсэн ажил, хүрсэн үр дүнг тайлагнаж байна.

Нэг. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр:

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр: “Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлэх аргачлал”-ын дагуу төрийн байгууллагуудын 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний дүнд тулгуурлан 2016 онд анхаарч ажиллах болон хангалтгүй хэрэгжүүлсэн асуудлуудыг тусгасан албан бичгийг үнэлгээнд хамрагдсан төрийн 124 байгууллагад хүргүүлсэн байна.

2016 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төрийн болон төрийн өмчийн оролцоотой 164 байгууллагыг төлөвлөгөөтэй болгох зорилт тавьснаас 133 байгууллага төлөвлөгөөгөө ирүүлсэн ба 31 байгууллага /АЗЗА/ өмнө нь “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” батлан хэрэгжүүлж байгаагүй тул төлөвлөгөөтэй, цахим хуудаатай болох талаар холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай санал солилцож дээрх байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудад аргачлалын 2 дугаар хавсралтыг хүргүүлээ.

Газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Гадаад хэргийн яам, Ашигт малтмалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Дундговь аймаг түүний 14 суманд авлигаас урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, заавар зөвлөгөө өгөх, 2016 оны авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, арга зүйн удирдлагаар хангах, хууль тогтоомжуудыг сурталчлах, сургалт зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэв.

“Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгаа”-гаар эрүүл мэндийн салбар бусад төрийн байгууллагуудын дунджаас доогуур үнэлгээ авсан эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалтан, хуулийн болон санхүү хариуцсан нийт 130 гаруй албан хаагчийн дунд “Эрүүл мэндийн салбарын авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг танилцуулах уулзалт, хэлэлцүүлэг”-ийг 2016 оны 3 дугаар 17-ний өдөр зохион байгуулсан нь үр дүнтэй болов.

“Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ”, Авлигын индекс, “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын шалтгаан, нөхцөл” зэрэг судалгааны дүнд тулгуурлан барилга, уул уурхай, боловсролын салбарт тодорхой ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна. Тухайлбал, холбогдох ажилтнуудад судалгааны дүнг танилцуулах, гарын авлага түгээхийн зэрэгцээ уулзалт, хэлэлцүүлгүүдийг амжилттай зохион байгуулсан болно.

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс нийт 6 журам, 1 тогтоол, 1 дүрэм хүчингүй болгуулахаар, 1 гэрээг хууль тогтоомжид нийцүүлэхээр албан бичгүүдийг хүргүүлж, 3 байгууллагын ёс зүйн дүрэмд санал өгсөн байна.

Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 11 гомдол мэдээллийг хүлээн авснаас хуулийн хугацаанд 10 гомдол хянан үзэж, одоо ажиллагаанд 1 гомдол байна.

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Ч.Байгальмаа нь ажилчиддаа урамшуулал олгож, олгосон урамшууллын мөнгөнөөс буцаан авсан тухай гомдлыг хүлээн авч хуульд заасан үндэслэл журмын дагуу холбогдох ажиллагааг хийж 3 асуудал бүхий зөвлөмж хүргүүлээ.

Соён гэгээрүүлэх чиглэлээр: 2016 онд зохион байгуулах сургалтын нэгдсэн төлөвлөгөө, хуваарийн төслийг боловсруулж, батлуулсан бөгөөд 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 56 удаагийн сургалт зохион байгуулж 3132 хүнийг сургалтад хамруулжээ. Эдгээр

сургалтын 83.6 хувийг төлөвлөгөөний дагуу, 16.4 хувийг тухайн байгууллагын хүсэлтээр зохион байгуулжээ.

2015 онд эхлүүлсэн зорилтот бүлэгт тохирсон хөтөлбөрт сургалт болох “Шударга нийгмийн төлөө хамтдаа” сэдвээр 1 дүгээр сарын ээлжит сургалтыг 21 аймгийн ИТХ-ын 15 нарийн бичгийн дарга нарт, 2 дугаар сарын сургалтыг МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 2 дугаар курсын 30 оюутанд, 3 дугаар сарын сургалтыг Чингэлтэй дүүргийн хороодын зохион байгуулагч, нийгмийн 30 ажилтанд газрын чиг үүрэгтэй танилцах, авлига, ашиг сонирхлын зөрчил, түүний шалтгаан, хор хөнөөлийн талаар ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр амжилттай зохион байгууллаа.

Хоёр. Хяналт шалгалт, дүн шинжилгээний чиглэлээр:

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн чиглэлээр: Тус газарт хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлэх албан тушаалтны нэрсийн жагсаалтыг шинэчлэн гаргасан бөгөөд мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр буюу түүнтэй адилтгах 277 албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэж байгаа 269 албан тушаалтан хуулийн хугацаанд мэдүүлгээ 100 хувь шинэчлэн мэдүүлснийг бүртгэсэн байна.

Төрийн болон орон нутгийн захиргааны төв 109 байгууллагын мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2016 оны тайлан /ХАСХОМ 1, 2, 3 тайлан, эрх бүхий албан тушаалтны бичмэл тайлан/, мэдээг цаасаар буюу цахим хэлбэрээр гаргуулан авч нэгтгэх ажлыг зохион байгуулав.

Улсын хэмжээнд 39853 мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс 39850 мэдүүлэг гаргагч буюу 99,9 хувь нь бүртгүүлсэн. Үүнээс хуульд заасан хугацаанд 39848 мэдүүлэг гаргагч бүртгүүлсэн бол 2 мэдүүлэг гаргагч хугацаа хожимдуулсан, 3 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гаргаж өгөөгүй байна.

2015 оны мэдүүлгээ хуульд заасан хугацаанд гаргаагүй буюу хугацаа хожимдуулсан зөрчилтэй мэдүүлэг гаргагч нарт дараах хариуцлагыг ногдуулсан байна. Үүнд:

Мэдүүлгээ хугацаа хожимдуулсан 2 албан хаагчид: Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29.2.1 дэх заалтыг үндэслэн Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгч Ц.Эрдэнэбаярт тус дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 03 сарын 14-ний өдрийн 22 тоот тогтоолоор “сануулах”; мөн Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа, хүний нөөцийн газрын дарга А.Ундрахт тус хорооны даргын 2016 оны 03 сарын 17-ны өдрийн 92 дугаар тушаалаар “сануулах”;

Мэдүүлгээ гаргаж өгөөгүй 3 албан хаагчид: Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.4, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29.2.4 дэх заалтыг үндэслэн Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгч Ч.Дэчингалсанд тус дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 03 сарын 14-ний өдрийн 22 дугаар тогтоолоор сарын урамшууллыг 20 хувиар 3 сарын хугацаагаар “бууруулж”, 2015 оны мэдүүлгийг нөхөн гаргуулсан;

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч Л.Гэрэлт-Одод тус дүүргийн ИТХ-ын 2016 оны 03 сарын 17-ны өдрийн 105, 2016 оны 03 сарын 31-ний өдрийн 139 тоот албан бичгээр тус тус зөвлөмж өгч “анхааруулан”, 2015 оны мэдүүлгийг нөхөн гаргуулсан;

Төрийн тусгай хамгаалалтын газрын Харуулын албаны дарга Ж.Самбалхүндэвийг тус газрын даргын 2016 оны 03 сарын 10-ны өдрийн Б/64 тоот тушаалаар “ажлаас халах” сахилгын шийтгэлийг тус тус ногдуулсан байна.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн нэгдсэн тайлан, мэдээний дүнгээс үзэхэд хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлтийн талаар мэдүүлсэн 920, ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл гаргасан 26189, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар гаргасан 786, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг

гаргасан 5589, давхар ажил эрхлэлтийн талаар танилцуулсан 140, ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдээлсэн 15 албан тушаалтан байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журмын дагуу нийтийн албан тушаалтнуудын 2015 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн бүртгэсэн тухай танилцуулга мэдээг бэлтгэж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд, холбогдох хуулийн дагуу Авлигатай тэмцэх газрын 122 албан хаагчийн 2015 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн эх хувийг холбогдох тайлан, бүртгэл, нэрсийн жагсаалтын хамт Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд тус тус хүргүүлсэн байна.

Хяналт шалгалт: Батлагдсан төлөвлөгөөний дагуу Монгол-Оросын хамтарсан “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг, Хөдөлмөрийн яам, Газрын тосны газар, Дундговь аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын газар, харьяа агентлагууд, Иргэний нисэхийн ерөнхий газарт бүрдүүлэлтийн хяналт шалгалтын ажлыг 2016 оны 1 дүгээр улиралд зохион байгуулсан бөгөөд хяналт шалгалтын үр дүнг газрын удирдлагад танилцууллаа.

Хяналт шалгалтын мөрөөр “Улаанбаатар төмөр зам”-ын даргын тушаалаар 4, Хөдөлмөрийн сайдын тушаалаар 1, тус яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 3 албан тушаалтанд тус тус “сануулах” сахилгын шийтгэл ногдуулсан бол мөн Хөдөлмөрийн яамны 2 албан тушаалтныг ажлаас чөлөөлж, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар шийдвэрлэсэн.

Төрийн захиргааны болон нутгийн захиргааны 109 байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах 113 эрх бүхий албан тушаалтнаас ирүүлсэн бүрдүүлэлтийн ажлын тайланг нэгтгэн, улсын хэмжээний нэгдсэн дүн мэдээг гаргасан болно.

2015 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ шинэчлэн гаргасан мэдүүлэг гаргагч нарын ангилал, зэрэглэлийн судалгаа:

Үзүүлэлт	ТЗ	ТТ	УТ	ТҮ	ТӨАТ	Бусад	Нийт
Тоо	12181	12047	7515	4226	269	3612	39850
Хувь	30,5%	30,2 %	18,8 %	10,6 %	0,7 %	9,2%	100%

Нийт мэдүүлэг гаргагчийн 26580 буюу 66,7 хувь нь Улаанбаатар хотод, 13270 буюу 33,3 хувь нь орон нутагт байна.

Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагад ажиллаж буй мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын судалгааг 2016 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар нэгтгэлээ. Судалгаагаар 1683 эрх бүхий албан тушаалтан бүртгэгдсэн бөгөөд үүнээс төрийн захиргааны болон нутгийн захиргааны төв 109 байгууллагад 113 эрх бүхий албан тушаалтан, салбар нэгжийн байгууллагад 1570 эрх бүхий албан тушаалтан байна.

Нийт 1683 эрх бүхий албан тушаалтны 22.3 хувь нь нийслэлд, 77.7 хувь нь орон нутагт байна. Өнгөрсөн жилийн судалгаагаар 1671 эрх бүхий албан тушаалтан байсан бол энэ жил 12-оор нэмэгдсэн байна.

Төрийн болон нутгийн захиргааны төв байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан “Нэгдсэн сургалт”-ыг 2016 оны 1 дүгээр сарын 7, 8-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 113 ЭБАТ оролцохоос 101 буюу 89,4 хувь нь оролцсон байна.

Мөн мэдүүлгийн бүрдүүлэлтийн хугацаанд “Мэдүүлэг гаргагчийн үүрэг, мэдүүлгээ шинэчлэн мэдүүлэхэд анхаарах зарим асуудал” сэдвээр сургалт зохион байгуулж нийт 29 байгууллагын 2331 мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудыг хамруулж гарын авлагаар хангасан байна.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмыг ашиглах, бүрдүүлэлтийн үйл ажиллагаатай холбоотой заавар, зөвлөмжийг эрх бүхий албан тушаалтнуудад болон мэдүүлэг гаргагч нарт биечлэн буюу утсаар, и-мэйлээр байнга өгч ажиллалаа.

Хяналт, шалгалтын чиглэлээр: Тайлант хугацаанд нийт 119 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах аас 18 мэдүүлгийг шалгаж дууссан ба улирлын эцэст 101 албан тушаалтны мэдүүлгийг шалгаж байна.

Нийт мэдүүлгийн 60 буюу 86.9 хувийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, 2 буюу 2,8 хувийг иргэний гомдол, мэдээллээр, 7 буюу 9,8 хувийг МШХ-ийн хүсэлтээр тус тус шалгасан байна.

Тайлант хугацаанд 71 албан тушаалтны ХАСХОМ-ийг шалгасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 104-өөр буюу 40,57 хувиар буурсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулалт буурсан нь 2015 оны эхэнд 2014 оны үлдэгдэл 111 байсан ба 2016 оны эхэнд 2015 оны үлдэгдэл 29 байсан нь тоон үзүүлэлт буурахад нөлөөлж байна.

Өргөдөл гомдлын чиглэлээр: 2016 оны I улиралд албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан нийт 83 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авснаас тайлант хугацаанд 77 өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн, өмнөх оны үлдэгдлийг оруулаад одоо 22 өргөдөл, гомдол, мэдээлэл ажиллагаанд хянагдаж байна.

Хүлээн авсан өргөдөл, гомдлыг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 39 буюу 31,9 хувиар, хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдол нь 12 буюу 13,4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Хүлээн авсан нийт өргөдөл, гомдлын 44 буюу 53,01 хувийг нийслэл хотоос, 39 буюу 47,59 хувийг хөдөө, орон нутгаас ирүүлсэн бөгөөд Завхан, Баян-Өлгий, Дархан-Уул аймгаас ирүүлсэн өргөдөл гомдол ихэнх хувийг эзэлж байна.

2016 оны I улиралд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 1734 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авснаас 1644 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн, одоо 90 мэдүүлэг хянагдаж байна.

Хянан шалгасан мэдүүлгээс ашиг сонирхлын зөрчил үүсч болохуйц нөхцөл байдлыг тогтоож, анхааруулсан нийт 151, томилох эрх бүхий албан тушаалтнаас ирүүлээгүй, албан тушаалд томилсныхоо дараа ирүүлсэн, холбогдох материал дутуу ирүүлсэн 74 мэдүүлгийг хянах боломжгүй үндэслэлээр буцаан хүргүүлсэн.

Хянан шалгасан урьдчилсан мэдүүлгийг хүснэгтээр үзүүлбэл:

Нийт хүлээн авсан ХАСУМ	Хянан шийдвэрлэсэн ХАСУМ	АСЗ үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй	АСЗ үүсэх нөхцөл байдлыг тогтоож анхааруулсан	Илт АСЗ үүсэх нөхцөл байдал бий болсон	Хууль, журамд заасан үндэслэлээр буцаасан	Нарийвчлан шалгах аар	Үлдэгдэл
1734	1644	1414	151	3	74	2	90

Хариуцлага тооцуулсан байдлыг албаны хэмжээнд үзүүлбэл /шалгалтын төрлөөр/:

№	Хариуцлагын төрөл	Шалгалтын төрөл		Хариуцлага тооцуулсан албан тушаалтны тоо, бүгд
		ХАСХОМ-ийн хяналт шалгалтаар	Өргөдөл, гомдлын хяналт шалгалтаар	
1	Сануулсан	3	-	3
2	Цалинг бууруулсан	2	7	9
3	Албан тушаал бууруулсан	-	-	-
4	Ажлаас халсан	1	3	4
5	Бусад	-	2	2
	Дүн	6	12	17

Гурав. Мөрдөн шалгах үйл ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд нийт 242 гомдол, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 90 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16.7 хувиар буурсан.

Гэмт хэргийн шинжтэй 2015 оны үлдэгдэл 13 гомдол, мэдээлэл, шинээр хүлээн авсан 90 гомдол, мэдээлэл, нийт 103 гомдол, мэдээллийг хянан үзсэнээс 21 гомдол, мэдээлэл буюу 20.4 хувьд эрүүгийн хэрэг үүсгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 0.4 хувиар өссөн, 59 гомдол, мэдээлэл буюу 57.3 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан нь өмнөх оны мөн үеийнхээс 2.3 хувиар өссөн, 12 гомдол, мэдээлэл буюу 11.6 хувийг харъяаллын дагуу шилжүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 0.8 хувиар өссөн бөгөөд ажиллагаанд 11 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 89.4 хувьтай байна.

Хянан үзсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг агуулга, холбогдох байгууллага, салбараар нь авч үзвэл нийтийн алба, төрийн албаны үйл ажиллагаанд хамаарах 94 гомдол, мэдээллээс төрийн улс төрийн албанд хамаарах 17, төрийн захиргааны албанд хамаарах 38, төрийн тусгай албанд хамаарах 12, төрийн үйлчилгээний албанд хамаарах 27 гомдол, мэдээлэл, бусад салбарт хамаарах 9 гомдол, мэдээллээс хувийн хэвшлийн үйл ажиллагаанд хамаарах 3, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 1, бусад 5 гомдол, мэдээлэл шалгагдсан байна.

Хянан үзсэн гомдол, мэдээллийг хүлээн авсан хэлбэрээр нь ангилвал албан бичгээр болон шуудангаар 56, биечлэн 44, факсаар 3 гомдол, мэдээлэл тус тус иржээ.

Тайлант хугацаанд хуульд заасан харьяаллын 165 үйлдэл, 187 холбогдогчтой 120 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан. Мөрдөн байцаалт явуулсан нийт хэргийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилвал төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 48 буюу 21.3 хувь, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 7 буюу 3.1 хувь, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 17 буюу 7.6 хувь, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 6 буюу 2.7 хувь, хээл хахууль авах 37 буюу 16.5 хувь, хээл хахууль өгөх 34 буюу 15.1 хувь, хээл хахуульд зуучлах 10 буюу 4.5 хувь, хууль бусаар хөрөнгөжих 2 буюу 0.9 хувь, мөнгө угаах 4 буюу 1.8 хувь, бусад хэрэг 60 буюу 26.7 хувийг эзэлж байна.

Мөрдөн шалгасан эрүүгийн хэргээс 21 хэргийг буюу нийт шалгасан хэргийн 17.5 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 15 хэргийг буюу 12.5 хувийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар, 7 хэргийг буюу 5.8 хувийг харъяаллын дагуу шилжүүлж, 10 хэргийг буюу 8.3 хувийг эрүүгийн хэрэгт нэгтгэж, 5 хэргийг түдгэлзүүлж, одоо 62 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй мөрдөн байцаалтын ажиллагаа хийгдлээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад мөрдөн шалгасан хэрэг 4-өөр буюу 18.8 хувиар өссөн, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 4-өөр буюу 23.5 хувиар өссөн, хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 3-аар буюу 16.7 хувиар буурсан, харъяаллын дагуу шилжүүлсэн хэрэг 1-ээр буюу 12.5 хувиар буурсан, ажиллагаанд байгаа хэрэг 20-оор буюу 47.6 хувиар өссөн дүнтэй байна.

Мөрдөн шалгасан хэргийн 53 хэргийг буюу 44.2 хувийг шийдвэрлэсэн, хуулийн анхны хугацаанд хэрэг шийдвэрлэлт 37.7 хувьтай.

Яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн хэргээс Баянгол дүүргийн 51 дүгээр дунд сургуулийн захирал Ю.Энхтуул нар, Архангай аймгийн Булган сумын ИТХ-ын дарга Ц.Төрхүү нар, Баянгол дүүрэг дэх Замын цагдаагийн тасгийн зохицуулагч цагдаа Ч.Отгон нарын 8 хүнд холбогдох нийт 4 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн.

Мөрдөн байцаагч нарын ажлын ачааллыг дунджаар авч үзвэл 1 мөрдөн байцаагч 4.3 гомдол, мэдээлэл, 5.0 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.

Шүүх, прокуророос эхний улиралд давхардсан тоогоор эрүүгийн 20 хэрэг нэмэлт мөрдөн байцаалтанд буцсан, эрүүгийн хэрэг үүсгэх саналтай 3 тогтоолыг прокурор хүчингүй болгосон,

эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 3 материалд прокурор эрүүгийн хэрэг үүсгэсэн. Шүүх, прокуророос буцсан хэргүүдтэй хэлтэс, албаны дарга нэг бүрчлэн танилцаж зохих үүрэг, даалгаврыг өгч, хэргийг шуурхай, чанартай шийдвэрлэхэд анхаарч ажиллаж байна.

Эрүүгийн хэрэгт холбогдон 187 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49.6 хувиар өссөн, хэргийн холбогдогчдыг албан тушаалын байдлаар нь авч үзвэл төрийн улс төрийн 15 буюу 8.0 хувь, төрийн захиргааны 24 буюу 12.8 хувь, төрийн тусгай 24 буюу 12.8 хувь, төрийн үйлчилгээний 33 буюу 17.7 хувь, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан, энгийн иргэд 91 буюу 48.6 хувийг эзэлж байна.

Гэмт хэргийн улмаас 28 тэрбум 681.5 сая төгрөгийн хохирол учирснаас мөрдөн байцаалтын шатанд 787.6 сая төгрөгийг нөхөн төлүүлж, 33.8 сая төгрөгийн техник 1 ш, 573.5 сая төгрөгийн автомашин 9 ш, 929.0 сая төгрөгийн орон сууц 6 ш, 124.5 сая төгрөгийн хашаа байшин 2 ш, 20 сая төгрөгийн авто зогсоол 1 ш, 18 сая төгрөгийн мал, бэлэн мөнгө 600.0 сая, нийт 2 тэрбум 298.8 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэн хамгаалсан ба хээл хахуулийн хэмжээ автомашин 6 ш үнэлгээ 290.0 сая, бэлэн мөнгө 913.5 сая, нийт 1 тэрбум 203.5 сая төгрөг байна.

Дөрөв. Судалгаа, шинжилгээний чиглэлээр:

Судалгаа: Шударга байдлын үнэлгээний 2015 оны судалгаанд хамруулах байгууллагын нэрсийг гаргаж газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/131 тоот тушаалаар батлуулан, 63 байгууллагаас төрийн үйлчилгээ авсан 2370 иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, 1410 төрийн албан хаагч, 630 шинжээчээс мэдээлэл цуглуулах ажлыг судалгааны компаниар гүйцэтгүүлж, тухай бүрт нь заавар, чиглэл өгч ажиллав. Судалгааны мэдээллийг гүйцэтгэгч компаниас хүлээн авч, судалгааны тооцооллыг хийж үр дүнг гаргаж, тайланг бэлтгэж байна.

Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолын дагуу Улс төр, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаархи төсөөлллийн 2015 оны судалгааг зохион байгуулах ажлын хүрээнд 66 шинжээчдээс мэдээлэл цуглуулах ажлыг хөндлөнгийн байгууллагаар хийлгэв. Судалгааны мэдээллийг гүйцэтгэгч компаниас хүлээн авч, судалгааны тооцооллыг хийж үр дүнг гаргаж, тайланг бэлтгэж байна.

Хүүхдийн шударга байдлын түвшин болон хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахиу болон авлигыг үл тэвчих байдал ямар түвшинд байгааг тодорхойлох, өсвөр үеийнхнийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, шударга бус хандлагаас нь урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтоох зорилгоор Хүүхдийн шударга байдал-2015 судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран цахим хэлбэрээр судалгааны асуулгыг “Survey monkey” программыг ашиглан Монгол Улсын 21 аймаг, 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 7-11 дүгээр ангийн 1929 сурагчдаас авав. Судалгааны тооцооллыг хийж үр дүнг гаргаж, тайланг бэлтгэв.

Шинжилгээ: Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Улсын Их Хурал авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаар Авлигатай тэмцэх газрын мэдээллийг жил бүр мэдээлнэ” гэж заасны дагуу “Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал”-ын талаарх 2015 оны мэдээллийг боловсруулж УИХ-д хүргүүлээ.

Мэдээлэл бэлтгэх ажлын хүрээнд авлигын нөхцөл байдлыг тодорхойлох чиглэлээр дотоодын болон олон улсын байгууллагын зүгээс хийгдсэн судалгаануудын талаарх танилцуулга бэлтгэж, хэлтсүүдээс холбогдох мэдээллийг авч, мэдээллийн төсөлд тусган эцэслэн боловсруулав.

Ази, номхон далайн орнуудын шударга байдлын сүлжээ “AP-INTACT”, “Транспарэнси Интернэшнл” байгууллагын ил тод байдлын мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх нийтлэл, үйл явдал, мэдээллийг судлан, ажилтнууд хуваарийн дагуу 7 хоног бүрээр түүвэрлэн орчуулж, “Гадаад мэдээний тойм” 1-13 дугаарыг бэлтгэн Газрын удирдлага болон хэлтсийн дарга нарт танилцуулж, мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулан, байгууллагын Хэвлэл, олон нийттэй харилцах ажилтантай хамтран шаардлагатай мэдээллийг олон нийтэд хүргэж ажиллав.

“Авлигатай тэмцэх газарт хүлээн авсан гомдол, мэдээлэл, тэдгээрийн шийдвэрлэсэн байдлын шинжилгээ, гомдол мэдээлэлд дурдсан нөхцөл байдалд үндэслэн авлигын гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийн шинжилгээ хийх” ажлын хүрээнд Газрын даргын 2013 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/81 дугаар тушаалаар батлагдсан “Иргэд байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх журам”-ын 6.2-т заасны 2015 оны 12 дугаар сар болон 2016 оны 1, 2 дугаар саруудад Авлигатай тэмцэх газарт хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэн газрын удирдлагад танилцуулж, байгууллагын цахим хуудсанд байршуулан, Хэвлэл, олон нийттэй харилцах ажилтантай хамтран шаардлагатай мэдээллийг олон нийтэд хүргэж ажиллаа.

Өргөдөл, гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газарт 2015 онд хүлээн авсан нийт өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн байдлыг мэдээллийн санд оруулан, дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэн газрын удирдлага болон хэлтсүүдэд танилцуулав.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР